



**ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИК, СОЁЛ,
БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МАЛАЙЗ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

**Монгол Улсын Засгийн газар, Малайз Улсын Засгийн газар,
цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэнэ/**

хоёр орны хоорондын найрамдалт харилцааг улам бүр
бэхжүүлэн, нийгэм, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан - техник,
соёл, боловсрол болон бусад салбарын хамтын ажиллагааг
хөгжүүлэхийг **эрмэлзэн,**

ийнхүү хамтран ажиллах нь хоёр орны нийтлэг сонирхолд
нийцэхээс гадна тэдгээрийн ард түмний нийгэм, эдийн засгийн
хөгжилд тус дөхөм болно гэдэгт **итгэн,**

Дорхи зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд тус тусын оронд хүчин төгөлдөр
мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд эдийн засаг, шинжлэх
ухаан, техник, соёл, боловсролын салбар дахь харилцан ашигтай
хамтын ажиллагааг хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд хамтын ажиллагааны тодорхой
салбаруудыг хамтран тодорхойлж байна.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд хоёр орны хооронд шинжээчид,
мэргэжилтэн, зөвлөх, дадлага хийгчид болон энэхүү Хэлэлцээрийн 2
дугаар зүйлд заасан хамтын ажиллагаа, салбарын талаар холбогдох
мэдээлэл харилцан солилцоход тус дөхөм үзүүлж, дэмжинэ.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу
гүйцэтгэх хөтөлбөр, төсөл зэргийг хэрэгжүүлэх зорилгоор тусгайд нь

хэлэлцээр байгуулж болно. Ийнхүү байгуулах хэлэлцээрээр тухайн хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлно.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр энэхүү Хэлэлцээр болон түүний дагуу байгуулсан аливаа хэлэлцээрийн хэрэгжүүлэх явцад хүлээн авсан нууц баримт бичиг, мэдээ болон бусад мэдээллийн нууцыг хадгална.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талынхаа хүсэлтээр энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх үүднээс албаны өндөр түвшинд хэлэлцээ хийж байна. Хэлэлцээ явуулах газар болон хугацааг хоёр Тал хамтран шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх арга зам, хэлбэрийг авч хэлэлцэхээс гадна Хэлэлцээрийн дагуу гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.

8 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, түүнийг хянан засварлах тухай хүсэлтээ бичгээр гаргаж болно. Энэхүү Хэлэлцээрт оруулах аливаа нэмэлт өөрчлөлт болон засварыг Хэлэлцэн тохирогч Талууд зөвшөөрч, бичгээр үйлдэх бөгөөд энэ нь уг Хэлэлцээрийн салшгүй хэсэг болно. Аливаа нэмэлт өөрчлөлт болон засвар нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

9 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг тайлбарлах, хэрэгжүүлэхэд гарч болох аливаа санал зөрөлдөөн болон маргаантай асуудлыг дипломат шугамаар, эв зүйгээр зохицуулна.

10 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү Хэлэлцээрийг таван жилийн хугацаатай байгуулсан бөгөөд тухайн хугацаа дууссаны дараа жил жилээр аяндаа сунгагдаж байна. Хэлэлцэн тохирогч аль ч Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай хүсэлтээ бичгээр, Хэлэлцээрийн хүчинтэй байх дурдсан хугацаа дуусахаас 6 сарын өмнө дипломат шугамаар мэдэгдэж болно.

**11 дүгээр зүйл**

Энэхүү Хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа дуусах, эсхүл түүнийг цуцлах нь түүний үндсэн дээр байгуулсан бусад протокол, тохиролцоо, гэрээ, хэлэлцээрт нөлөөлөхгүй. Энэ заалт нь энэхүү Хэлэлцээрийн үндсэн дээр авч хэрэгжүүлсэн буюу эхэлсэн бөгөөд хугацаа нь дуусаагүй буюу мөрдөж буй аливаа үүрэг, төслийн хувьд нэгэн адил мөрдөгдөнө. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр тохиролцоогүй бол ийм үүрэг, төслийг хүчинтэй байх тухайн хугацааг дуустал үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Өөр өөрсдийн засгийн газраас эрх олгогдсон дорхи хүмүүс энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо, 1997 оны 9 сарын 09-ны өдөр монгол, малай, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад эерүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**МАЛАЙЗ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨЖ**